



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
МӨСТ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/151/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөст хот

2023 он

Мөст аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

Цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын талаар 2022 онд завсрын аудит, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.	16
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Залруулсан алдаа	
5.2 Төлбөрийн акт	16
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МӨСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА З.БОЛОРМАА ТАНАА

2023.03.22 № 02/104
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, эмийн тооцоо бодоогүй, сахилгын арга хэмжээтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал, бүрэн ажиллаагүй хүнд түлш хөнгөлөлт олгосон, анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан, түлээ нүүрс, шатахуун, эмийн зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэгтэй холбоотой нийт 48.5 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь тусгай зориулалтын шилжүүлгээс буюу улсын төсвөөс санхүүждэг байсан 2022 онд иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар тооцон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгодог болсон нь нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээгүй болно.

0210203³

Бусад асуудлын хэсэг

Тус Эрүүл мэндийн төв нь сумын 802 гаруй өрхийн 3158 гаруй иргэнд давхардсан тоогоор 5031 амбулаторийн үзлэгт хамруулж 402 иргэнийг хэвтүүлэн эмчилж 2893 ор хоног, дундаж ор хоног 7.3, орны фонд ашиглалт 48 хувьтай, 203 алсын дуудлагад үйлчилж, 53 эх тэрүүлсэн статистик үзүүлэлттэй байна.

Тус байгууллага нь тайлант онд 9 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 91.3 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Мөн тайлант онд эм эмнэлгийн хэрэгслийн өмнөх онд зарцуулсан зарлагыг санхүүгийн программд зарлагдаагүйтэй холбоотой 50.1 сая төгрөгөөр өмнөх үр дүн дансанд залруулга хийсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>171,827,528.11</u>	<u>137,800,742.55</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	645,625.34	3,764,314.62
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	645,625.34	3,764,314.62
3121	Төгрөг	645,625.34	3,764,314.62
31211	Төрийн сангийн харилцах	645,625.34	3,764,314.62
33	АВЛАГА	23,956,435.87	3,853,219.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	764,980.87	656,043.46
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	22,212,000	-
335	Бусад авлага	979,455	3,197,176.24
3351	Байгууллагаас авах авлага	979,455	3,197,176.24
35	БАРАА МАТЕРИАЛ	147,225,466.90	130,183,208.23
351	Түүхий эд материал	97,987,515.47	53,807,603.68
35130	Эм боох материал	97,987,515.47	53,807,603.68
354	Хангамжийн материал	49,237,951.43	76,375,604.55
35410	Бичиг хэргийн материал	560,500	4,861,350
35430	Сэлбэг хэрэгсэл	1,940,000	3,360,000
35440	Түлш, шатах тослох материал	3,980,000	1,800,000
35460	Хүнсний материал	1,100,800.20	6,615,315.20
35470	Бусад хангамжийн материал	41,656,651.23	59,738,939.35
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>585,403,374.54</u>	<u>595,842,764.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	585,403,374.54	595,842,764.09
392	Биет хөрөнгө	575,099,374.54	585,538,764.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	513,354,000	513,354,000
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,138,700.41)	(59,005,847.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,752,000	122,651,998
39204	Хуримтлагдсан элэгдэл	(83,278,500.10)	(91,088,166.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,608,331.83	188,875,755.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,808,475.09)	(101,299,539.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,513,406	48,299,406
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,902,688)	(36,248,842)
393	Биет бус хөрөнгө	10,304,000	10,304,000
39301	Программ хангамж	880,000	880,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000)	(880,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,304,000	10,304,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>757,230,902.65</u>	<u>733,643,506.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>73,281,642.56</u>	<u>6,297,680.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,281,642.56	6,297,680.90
413	Өглөг	73,281,642.56	6,297,680.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,997,896.65	1,999,173.48
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	66,659,401.14	1,476,962.64
4136	Бусад өглөг	3,624,344.77	2,821,544.77
41361	Байгууллагад төлөх өглөг	1,407,652	2,604,852

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,216,692.77	216,692.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	683,949,260.08	727,345,825.74
51	Засгийн газрын хувь оролцоо	683,949,260.08	727,345,825.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	176,837,308	176,837,308
51101	Өмч: - төрийн	176,837,308	176,837,308
512	Хуримтлагдсан үр дүн	92,163,577	135,560,142.66
51210	Өмнөх үеийн үр дүн	92,163,577	41,969,533.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	93,590,609.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	414,948,375.08	414,948,375.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	757,230,902.64	733,643,506.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	723,531,622.96	779,749,812.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	513,247,960.96	45,351,532.12
120	Нийтлэг татварын бус орлого	19,859,660.96	45,351,532.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,859,660.96	45,351,532.12
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,859,660.96	45,351,532.12
122	Тусламжийн орлого	33,332,000	-
122001	Хандив тусламж /дотоод/	33,332,000	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	460,056,300	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	460,056,300	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	210,283,662.00	734,398,280.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,672,880	310,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,672,880	310,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,906,000	23,648,070
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,906,000	23,648,070
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	23,000,000	-
1330	Төсвийн захирагчдаас	23,000,000	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	133,704,782	710,440,210
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	133,704,782	710,440,210
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	698,234,546.76	686,159,202.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	698,234,546.76	686,159,202.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	663,034,546.76	686,159,202.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,825,371.29	418,154,972.88
210101	Үндсэн цалин	398,825,371.29	418,154,972.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,180,085.77	52,132,650.54
210201	Тэтгэврийн даатгал	36,037,614.60	35,531,058.99
210202	Тэтгэмжийн даатгал	4,059,369.87	4,150,398.42

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,222,158.99	3,320,318.34
210204	Ажилгүйдлийн даатгал	805,539.09	830,079.08
210205	Эрүүл мэндийн даатгал	8,055,403.22	8,300,795.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,645,722.00	17,266,573.00
210301	Гэрэл, цахилгаан	2,795,972.00	3,586,573
210302	Түлш, халаалт	13,849,750	13,545,000
210303	Цэвэр, бохир ус	-	135,000
2104	Хангамж, бараа материалын зардал	30,917,840	61,487,759.75
210401	Бичиг хэрэг	4,486,400	4,629,350
210402	Тээвэр, шатахуун	24,088,440	37,839,830
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,253,000	3,026,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000	952,928
210408	Бараа материал акталсны зардал	-	15,039,651.75
2105	Нормативт зардал	90,485,744.58	82,122,985.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,501,294.58	71,867,605.92
210502	Хоол, хүнс	12,984,450	10,255,380
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,839,800	5,464,700
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,527,200
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	937,500
210604	Урсгал засвар	2,839,800	-
2107	Томилолт, зочны зардал	984,000	1,262,000
210702	Дотоод албан томилолт	984,000	1,262,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	756,978	1,925,228
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	632,050
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000	450,000
210803	Даатгалын үйлчилгээ	120,000	304,790
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,160	127,420
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	97,210	121,240
210807	Газрын төлбөр	20,608	24,728
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	265,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,399,005.12	46,342,332.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,107,400	3,828,300
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,291,605.12	42,514,032.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,200,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,200,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,200,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>25,297,076.20</u>	<u>93,590,609.58</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>625,127,962</u>	<u>756,610,280</u>

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,056,300	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	460,056,300	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	460,056,300	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,071,662	756,610,280
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,672,880	310,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,672,880	310,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,906,000	23,648,070
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,906,000	23,648,070
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	111,492,782	732,652,210
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	111,492,782	732,652,210
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>624,482,336.66</u>	<u>753,491,590.71</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,482,336.66	753,491,590.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	589,282,336.66	753,491,590.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,714,095.66	420,095,641.02
210101	Үндсэн цалин	223,102,600	241,717,700
210102	Нэмэгдэл	118,142,400	137,724,442.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,308,000	8,149,000
210104	Урамшуулал	51,161,095.66	32,504,498.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,865,146	50,847,355.56
210201	Тэтгэврийн даатгал	37,821,631	35,364,200
210202	Тэтгэмжийн даатгал	4,010,903	4,033,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,208,723	3,245,900
210204	Ажилгүйдлийн даатгал	802,181	715,168.27
210205	Эрүүл мэндийн даатгал	8,021,708	7,489,087.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,656,000	15,821,045
210301	Гэрэл, цахилгаан	2,196,000	2,196,000
210302	Түлш, халаалт	12,325,000	13,490,045
210303	Цэвэр, бохир ус	135,000	135,000
2104	Хангамж, бараа материалын зардал	31,218,855	58,281,814
210401	Бичиг хэрэг	1,583,500	4,693,400
210402	Тээвэр, шатахуун	24,838,855	44,020,586
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,796,500	3,951,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000	3,282,828
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,334,000
2105	Нормативт зардал	79,719,240	165,963,607.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,719,240	146,698,446.74
210502	Хоол, хүнс	10,000,000	16,626,060.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000	2,639,100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,250,000	29,446,600
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000	18,019,200
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3,677,500
210604	Урсгал засвар	2,250,000	7,749,900
2107	Томилот, зочны зардал	984,000	1,262,000

210702	Дотоод албан томилолт	984,000	1,262,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,000	1,925,228
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	632,050
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000	450,000
210803	Даатгалын үйлчилгээ	120,000	304,790
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000	127,420
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000	121,240
210807	Газрын төлбөр	55,000	24,728
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	265,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000	9,848,300
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000	9,848,300
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,200,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,200,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,200,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>645,625.34</u>	<u>3,118,689.29</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	645,625.34	3,118,689.29
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	645,625.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	645,625.34	3,764,314.62

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308	420,699,095.08	50,037,597.31	647,574,000.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308	420,699,095.08	50,037,597.31	647,574,000.39
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,302,535.79)	(34,302,535.79)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308	414,948,375.08	92,163,577	683,949,260.08
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308	414,948,375.08	92,163,577	683,949,260.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(50,194,043.92)	(50,194,043.92)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308	414,948,375.08	41,969,533.08	633,755,216.16
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	93,590,609.58	93,590,609.58
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308	414,948,375.08	135,560,142.66	727,345,825.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	728,870,900	734,960,965.72	(6,090,065.72)	100.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	728,870,900	734,960,965.72	(6,090,065.72)	100.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,870,900	734,960,965.72	(6,090,065.72)	100.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,379,900	420,095,641.02	(15,715,741.02)	103.89
210101	Үндсэн цалин	225,541,700	241,717,700	(16,176,000)	107.17
210102	Нэмэгдэл	137,725,200	137,724,442.16	758	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,149,000	8,149,000	-	100
210104	Урамшуулал	32,964,000	32,504,498.86	459,501	98.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,547,500	50,847,355.56	(299,856)	100.59
210201	Тэтгэврийн даатгал	34,372,200	35,364,200	(992,000)	102.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,033,000	4,033,000	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,245,900	3,245,900	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	808,800	715,168.27	93,632	88.42
210205	Эрүүл мэндийн даатгал	8,087,600	7,489,087.29	598,513	92.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,081,000	15,821,045	259,955	98.38
210301	Гэрэл, цахилгаан	2,196,000	2,196,000	-	100.00
210302	Түлш, халаалт	13,750,000	13,490,045	259,955	98.11
210303	Цэвэр, бохир ус	135,000	135,000	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	51,845,000	51,046,228	798,772	98.46
210401	Бичиг хэрэг	4,816,500	4,693,400	123,100	97.44
210402	Тээвэр, шатахуун	37,095,000	37,095,000	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000	3,951,000	249,000	94.07
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,333,500	2,972,828	360,672	89.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000	2,334,000	66,000	97.25
2105	Нормативт зардал	155,577,600	154,668,568.14	909,032	99.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135,449,600	135,403,407.74	46,192	99.97
210502	Хоол, хүнс	16,894,500	16,626,060.40	268,440	98.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,233,500	2,639,100	594,400	81.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,834,000	29,446,600	6,387,400	82.18
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,046,500	18,019,200	27,300	99.85
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,737,500	3,677,500	1,060,000	77.63
210604	Урсгал засвар	13,050,000	7,749,900	5,300,100	59.39
2107	Томилолт, зочны зардал	1,080,000	1,262,000	(182,000)	116.85
210702	Дотоод албан томилолт	1,080,000	1,262,000	(182,000)	116.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,025,900	1,925,228	1,100,672	63.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,000	632,050	67,950	90.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	616,500	450,000	166,500	72.99
210803	Даатгалын үйлчилгээ	350,000	304,790	45,210	87.08
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000	127,420	2,580	98.02
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	81,400	121,240	(39,840)	148.94
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000	-	300,000	-
210807	Газрын төлбөр	23,000	24,728	(1,728)	107.51

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	525,000	-	525,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,000	265,000	35,000	88.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500,000	9,848,300	651,700	93.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500,000	9,848,300	651,700	93.79
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	728,870,900	738,079,655	(9,208,755)	101.26
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,908,100	23,648,070	260,030	98.91
132001	Орон нутгийн төсвөөс	23,908,100	23,648,070	260,030	98.91
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	688,545,800	710,440,210	(21,894,410)	103.18
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	688,545,800	710,440,210	(21,894,410)	103.18
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,417,000	3,681,375	12,735,625	22.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	#DIV/0!
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,417,000	3,681,375	12,735,625	22.42
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ		310,000.00	(310,000)	#DIV/0!
122001	Хандив тусламж /дотоод/		310,000.00	(310,000)	#DIV/0!
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	645,625.34		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,764,314.62		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	-	100
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,290,880	18,530,625
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,290,880	18,530,625
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,290,880	18,530,625
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,790,739	-
210104	Урамшуулал	26,790,739	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,517,546	-
210201	Тэтгэврийн даатгал	2,391,931	-
210202	Тэтгэмжийн даатгал	281,403	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	225,123	-
210204	Ажилгүйдлийн даатгал	56,281	-
210205	Эрүүл мэндийн даатгал	562,808	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,243,855	6,925,586
210401	Бичиг хэрэг	500,000	-
210402	Тээвэр, шатахуун	2,743,855	6,925,586
2105	Нормативт зардал	42,346,740	11,605,039

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,346,740	11,605,039
2107	Томилолт, зочны зардал	392,000	-
210702	Дотоод албан томилолт	392,000	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,000,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,000,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,000,000	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,290,880	18,530,625
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,290,880	18,530,625
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	74,618,000	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,672,880	18,530,625

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мөст сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлэх хүрээний хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд чанартай, хүртээмжтэй үзүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулан, хүн амын эрүүлжүүлэх үйлсэд уламжлалт анагаах ухааныг өргөн ашиглах, ард иргэдэд эрүүл мэндийнхээ төлөө зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх гэсэн зорилтыг тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд:

- *Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай”*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөст сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “ДУНД” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөст сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.6 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.6	3.8	3.2
Авлага	24.0	3.8	(20.2)
Бараа материал	147.2	130.2	(17.0)
Үндсэн хөрөнгө	585.4	595.8	10.4
Нийт хөрөнгө	757.2	733.6	(23.6)
Өр төлбөр	73.3	6.3	(67.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	683.9	727.3	43.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	757.2	733.6	(23.6)

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсны дагуу Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар тоот албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 3.2 сая төгрөгөөр өссөн байна.
- ✓ Өмнөх онд Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 22.1 сая төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулж оны эцэст 3.8 сая төгрөгийн тээвэр шатахуун, эмийн авлагын үлдэгдэлтэй байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 17.0 сая төгрөгөөр буурсан нь 2017-2021 онуудад зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгслийн зарлагыг санхүүгийн программаас хасаагүйг залуулсан байна.
- ✓ Оны эхний өр төлбөрийг 66.3 сая төгрөгийг барагдуулан тайлант оны эцэст 6.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь барагдуулах боломжтой байна.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо дансны хувьд тайлант онд 93.6 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 482.1, орон нутгийн төсвөөс 20.0, эрүүл мэндийн даатгалын сангаас 33.2 сая төгрөг бүгд 535.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж тайлант оны эхэнд ЭМДС-аас 646.6, орон нутгаас 23.9, нийт 670.5 сая төгрөгөөр баталж, оны эцэст 728.9 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 710.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 23.6 сая төгрөг, ЭМГ-аас 0.3 сая төгрөг, өмнөх оны авлагаас 3.7 нийт 738.0 сая төгрөгийн санхүүжилт авч 734.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
1	71602/80302- Нэг иргэнд ногдох нормативаар	350.5	357.8	(7.3)	102.1
2	71602/81603- Үндсэн мэргэжлийн тусламж	338.1	337	1.1	99.7
3	71602/83603- Нэмэлт- дээд шатны төсвөөс хуваарилсан	16.4	16.4	-	100
4	71602/80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	17.8	17.6		99
5	71602/80112- Нийтлэг үйлчилгээ	6.1	6.1		100
ДҮН		728.9	734.9	-6.2	100.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны санхүүжилтийн авлага 22.2 сая төгрөгийг ЭМДС-аас авч 18.5 сая төгрөгийг өмнөх оны эм, шатахууны өр төлбөрийг барагдуулан, 3.7 сая төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 03 дугаар сарын 18-наас 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мөст аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03 албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 698.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 14.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн шатанд 10.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Мөст сумын ЭМТөв нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд албан томилолт, 10 дугаар зүйлд цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалттай холбоотой заалтууд хамаарахгүй байна.

15 дугаар зүйлд хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой төсвийн хөрөнгөөр камержуулалт, хөшиг 7.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш тайлант зарлагын 8 ажил гүйлгээг мэдээлээгүй, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн

тайлбар, шалтгаан, хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй, 147 мэдээллийг хугацаанд нь оруулсан, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5.1 Завсрын аудитын үр дүн

Завсрын аудитаар ажил хавсран ажилласан, ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнтэй нь уялдуулан олгоогүй, бараа материалын тайлан гаргалт, жолоочийн тооцоо бодолт хангалтгүй, хэрэгцээ шаардлагагүй ковидын түргэвчилсэн тестийг их хэмжээгээр нөөцөлсөн хугацаа дууссан төсвийг үр дүнгүй зарцуулсан зэрэг зөрчлийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 245.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 169.4 сая төгрөгийн албан шаардлага, 76.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 61.2 хувьтай байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	169.4	1	-	50.0
Зөвлөмж	3	76.0	2	55.0	72.4
Нийт дүн	5	245.4	3.0	55.0	61.2

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хөтөлбөр арга хэмжээний чиглэлээр хийгдсэн сургалт, эм, түлээ нүүрс болон шатахууны зарцуулалтыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 1.4 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- Өглөг 0.7 сая төгрөгөөр өмнөх онд илүү бүртгэснийг өмнөх үр дүн рүү,
- Тайлант үеийн үр дүнг 0.8 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 45.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 4.0 сая төгрөгийн төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлага, 41.6 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Сахилгын арга хэмжээтэй эмч мэргэжилтэнд улирлын мөнгөн урамшуулал, 7 дугаар сард ажилд орсон ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлт, ЭМС-ын А/295 тоот тушаалаар нийгмийн баталгааг хангах сарын аяны хүрээнд олгох урамшууллыг бүрэн олгосон, төсөвт батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл, байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй бараа материал худалдан авсан, шатахууныг зориулалт бусаар нийт 2.6 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг мөрдөөгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Эмч, мэргэжилтэнд томилолтын мөнгийг 1 өдөрт ноогдох тарифаар тооцон олгоогүй 1.4 сая төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, Сангийн сайдын 2022 оны 120 тоот тушаалын 1-д “Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24.0, аймгийн төвд 28.0, байрны зардлыг суманд 40.0, аймгийн төвд 90.0 мянган төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 110.0 мянган төгрөгөөр” гэсэн заалттай нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүйд буцаан олгох төлбөрийн акт,

5.2 Албан шаардлага / хариуцлага тооцуулах/

- Албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлээгүй байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, гэсэн заалтуудтай нийцээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

5.3.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тухайн мэргэжлээр ажиллаж байгаа эсэх нь тодорхой бус мэргэжилтэнд олгосон, төсөвт батлагдаагүй сургалтын төлбөрт 1.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, ЭМСайдын 2019 оны А/513 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн зэрэг олгох, нөхөн олгох хүчингүй болгох журам”-ын 9.4.1-д “ахлах, тэргүүлэх зэрэг анх олгосноос хойш тухайн мэргэжил, мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа нөхцөлд 10 жил”, 9.4.2-д журмын 9.4.1-д заасны дагуу мэргэжил, мэргэжлээр тасралтгүй 10 жил ажилласны дараа 1 удаа тухайн

мэргэшлийн зэргийг давтан хамгаалах шаардлагатай бөгөөд амжилттай давтан хамгаалсан нөхцөлд тухайн мэргэжил, мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа бүхий л хугацаанд" Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар "Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Журамд заасан мэргэжлээрээ ажиллахгүй ажилтанд зэргийн нэмэгдлийг олгохгүй байх

5.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөтөлбөр арга хэмжээний зардлыг үр дүнтэй зарцуулаагүй, ажлын тайлан гаргаагүй, хэчнээн хүн сургалтад хамруулсан эсэх тодорхой бус, бал, дэвтэр цайны материал олгох хэлбэрээр зохион байгуулж, үйл ажиллагааны зардалд 2.4 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх", Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар "Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Журамд заасан хөтөлбөр арга хэмжээний сургалтыг үр дүнтэй зохион байгуулан хэрэгжүүлсэн ажлын үр дүн хэрэгжилтийг тухай бүр тооцож тайлагнаж байх

5.3.3 Бараа материалын тайлан гаргалттай холбоотой асуудал

Илрүүлэлт Эмийн болон шатахуун, түлээ нүүрсний эд хариуцагчийн тайлан гаргалт хангалтгүй, жолоочийн тооцоог сар бүр бодоогүй, түлээ нүүрсийг 1 өдөрт хэчнээн хэмжээтэй зарцуулсан эсэх нь тодорхой бус бөөн дүнгээр зарлагдсан, шатахууны болон түлээ нүүрсний зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй 30.1 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ. Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна", НХМаягт ТМ-4-д Жолоочийн тооцооны хуудас, Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Бараа материалын тайланг сар бүр гаргах, жолоочийн тооцоог бодож хэвших

5.3.4 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүйгээс камержуулах, хөшиг худалдан авахад 7.7 сая төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.5-д

“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж Батлагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх

5.3.5 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд зааснаар цалингаас бусад 5 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Шилэн дансны хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг бүрэн мэдээлж ажиллах,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого илүү хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	1.4			1	1.4	1	1.4
Өглөг дутуу тусгасан	1	0.7			1	0.7	1	
Тайлант үеийн үр дүн дутуу илэрхийлсэн	1	0.8			1	0.8	1	0.8
Дүн	3	2.9	-	-	3	2.9	3	2.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсэн, сахилгын арга хэмжээтэй ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулал олгосон, батлагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулсан	1	2.6	1	2.6				-
Эмч, мэргэжилтнүүдэд томилолтын мөнгө бүрэн олгоогүй	1	1.4	1	1.4				-
Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тухайн мэргэжлээр ажиллаж байгаа эсэх нь тодорхой бус мэргэжилтэнд	1	1.4					1	1.4

олгосон, төсөвт батлагдаагүй сургалтын төлбөр төлсөн								
Хөтөлбөр арга хэмжээний зардлыг үр дүнтэй зарцуулаагүй, ажлын тайлан бүрэн бус	1	2.4					1	2.4
Эмийн болон шатахууны тайлан гаргалт хангалтгүй дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллаагүй, түлээ нүүрсийг 1 өдөрт хэчнээн хэмжээтэй зарцуулсан эсэх нь тодорхой бус бөөн дүнгээр зарлагдсан хяналт хэрэгжүүлээгүй	1	30.1					1	30.1
Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын ирүүлээгүй, өмнөх СТА-аар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй	1	-			1			
Дүн	6	37.9	2	4.0	1	-	3	33.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /сая.төгрөгөөр /

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Шилэн дансны тухай хуульд зааснаар цалингаас бусад 5 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй	1	-	1	-
Дүн	1		1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүйгээс камержуулах, хөшиг худалдан авсан	1	7.7	1	7.7
Дүн	1	7.7	1	7.7
Нийт дүн	2	7.7	2	7.7

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 45/A2160424

Ховд

ХОА-2022/151/НА/СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар улирлын мөнгөн урамшуулал, түлээ, нүүрсний хөнгөлөлтийг илүү олгосон, төсөвт батлагдаагүй орон тоонд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон, байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй бараа материал худалдан авсан, шатахууныг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой нийт 2616.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 2616936 /хоёр сая зургаан зуун арван зургаан мянга есөн зуун гучин зургаан төгрөгийг/-ийг хавсралтад заасны дагуу төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөст сумын Эрүүл мэндийн төвийн дарга З.Болормаа, нягтлан бодогч С.Ульянов нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 46/A2160424

Ховд

ХОА-2022/151/НА/СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар эмч, мэргэжилтэнд томилолтоор ажилласан хугацааны томилолтын мөнгийг холбогдох тогтоолоор баталсан тарифаар тооцон олгоогүй 1.4 сая төгрөгийн томилолтын мөнгийг дутуу олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2022 оны 120 тоот тушаалын 1-д "Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24.0, аймгийн төвд 28.0, байрны зардлыг суманд 40.0, аймгийн төвд 90.0 мянган төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 110.0 мянган төгрөгөөр" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захирааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1450000 /нэг сая дөрвөн зуун дөрвөн зуун тавин төгрөгийг/-ийг хавсралтад заасан албан хаагчдад буцаан олгох
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөст сумын Эрүүл мэндийн төвийн дарга З.Болормаа, нягтлан бодогч С.Ульянов нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  К.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ

1

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 02/A2160424

Ховд

ХОА-2022/151/НА-СТА-ТШЗ

ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мөст сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлээгүй Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчилтэй холбоотой Мөст сумын Эрүүл мэндийн төвийн дарга З.Болормаа, нягтлан бодогч С.Ульянов нарт хуульд заасны дагуу хариуцлага тооцон биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ хариуг албан бичгээр ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОВДБААТАР
АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ

¹ Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061